ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 02 өдөр Дугаар А/219 Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу тус сумын Онги 13 дугаар баг Төв-5 дугаар гудамж 521 тоотод байрлах 1 нэгж талбарын газар эзэмшигч иргэний эзэмшил газрыг хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг тус тус шилжүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны “Газар ашиглалтын зориулалтад өөрчлөлт оруулах тухай” А/218 дугаар захирамжийн хавсралтын Чулуунбатын Батсуурь (ЙВ80110418)-ийн холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (Ш.Адъяадолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:2021/Alban bichig/Zahiramj2021

Сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 21/219 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м^2/ Газраас	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м^2/ Газрыг	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа /жил/
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Ч.Батсуурь	ЙВ80110418	Амины орон сууц	547	Ч.Батсуурь	ЙВ80110418	Амины орон сууц	313	Онги 13 дугаар баг, Төв-5 гудамж, 521а тоот	21.6
					П.Бямбасүрэн	ЙЮ75040316	Амины орон сууц	234	Онги 13 дугаар баг, Төв-5 гудамж, 521б тоот	21.6

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР